

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Ажил олгогчийн сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго

- Ажил олгогч, захирал, менежер зэрэг байгууллагын дээд түвшний удирдлагад ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалан ажиллах шаардлагатай ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголтыг өгөхөд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2. Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, хандлага

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий **мэдлэг**
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх зайлшгүй мөрдөх хууль тогтоомжийн шаардлагуудын талаарх **мэдлэг**
3. Байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах талаарх ерөнхий **мэдлэг**
4. ХАБЭА-н үйл ажиллагааг урьдчилан сэргийлэлтийн зарчмаар хэрэгжүүлэх **хандлага**
5. ХАБЭА-н үйл ажиллагаанд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг төлөвлөн ажиллах **хандлага**

3. Сургалтад хичээл заах багшид тавигдах шаардлага:

1. Заавал биелүүлэх шаардлага
 - ХАБЭА-н талаарх мэдлэг, хандлагыг их дээд сургууль, төгсөлтийн дараах сургалт, ХАБЭА-н сургалтаар эзэмшсэн
 - ХАБЭА-н практик ажлын 5-аас доошгүй жилийн туршлагатай
2. Зөвлөмж шаардлага
 - ХАБЭА-н чиглэлээр удирдах ажлын туршлагатай
 - Байгууллагын ХАБЭА-н дүрэм, журам боловсруулж байсан туршлагатай

4. Сургалтын зохион байгуулалт:

Анги танхим, ажлын байр эсвэл цахим хэлбэрээр зохион байгуулна. Цахим сургалтын цаг нь нийт сургалтын цагийн 1/2-оос бага байна.

5. Цагийн багтаамж:

8 цаг

6. Үнэлгээ:

Дараахь шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно. Үүнд:

Ирц: Сургалтын бүх сэдвийн хичээлд хамрагдсан байх

Сорил: Эзэмшвэл зохих мэдлэгийн 80-аас багагүй хувийг эзэмшсэн нь сорилын шалгалтаар үнэлэгдсэн байх.

7. Сургалтын сэдэв

Д/д	Сэдэв	Цаг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	1
2	Үйлдвэрлэлийн ослын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан	1

	сэргийлэлтийн зарчим	
3	Мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	1
4	Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалтын зарчим	1
5	Байгууллагын ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалт, дүрэм, журам	1
6	ХАБЭА-н арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, санхүүжилт	1
7	ХАБЭА-н үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандарт	2
	Бүгд	8

8. Сургалтын агуулга

Сэдэв	Агуулга
Сэдэв 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий ойлголт	ХАБЭА-н тодорхойлолт, хамаарах асуудал
	Ажлын байранд түгээмэл тохиолддог ослын шалтгаан, аюултай хүчин зүйлс, тэдгээрийн талаарх практик жишээнүүд
	Ажлын байранд химийн аюултай ба хортой бодистой холбоотой осол, хурц хордлого
	Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэдэг ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн практик жишээ
	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний талаарх ерөнхий ойлголт ХАБЭА-н ажилтны үүрэг
Сэдэв 2. Үйлдвэрлэлийн ослын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюулын төрлүүд, жишээ
	Аюулын таньж илрүүлэх арга, осол үүсгэх эрсдэлийн үнэлэх арга
	Үйлдвэрийн ослын эрсдэлд хяналт тавих, бууруулах, арилгах арга хэмжээний эрэмбэ
	Ослын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг арилгасан талаарх практик жишээ
Сэдэв 3. Мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэдэг хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлс, жишээ
	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийн үндсэн төрлүүд, ач холбогдол
	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
	Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний эрэмбэ
Сэдэв 4. Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалт зарчим	Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн зорилго, ач холбогдол
	Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төрөл, зохион байгуулалт
	Ажилтны эрүүл мэнд үзлэгийн баримтад хийх тандалт судалгаа
	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг судлан бүртгэх
Сэдэв 5. Байгууллагын ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалт, дүрэм, журам	Байгууллагын ХАБЭА-н үйл ажиллагааг зохион байгуулах зарчим
	Ажил олгогчийн ХАБЭА-н манлайлал, ач холбогдол
	Байгууллагын ХАБЭА-н үйл ажиллагаанд ажилтны оролцоо, ач холбогдол

	Ажилтны үйл ажиллагааг идэвхжүүлэх, урамшуулах
	Байгууллагын ХАБЭА-н соёл хандлагыг нэвтрүүлэх, төлөвшүүлэх
	ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалтын сайн жишээ
Сэдэв 6. ХАБЭА-н арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, санхүүжилт	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний байгууллагад үзүүлэх нөлөө, үр дагавар
	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдол
	ХАБЭА-н арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
	ХАБЭА-н арга хэмжээний санхүүжилт, зардлын төрөл
Сэдэв 7. ХАБЭА-н үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт	<ul style="list-style-type: none"> ○ Хөдөлмөрийн тухай хууль, ○ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль ○ Эрүүл ахуйн тухай хууль ○ Нийгмийн даатгалын багц хууль ○ Эрүүгийн хууль ○ Зөрчлийн тухай хууль
	ХАБЭА-н талаар ажил олгогчийн эрх, үүрэг
	<p>ХАБЭА-н холбогдох дүрэм, журам:</p> <ul style="list-style-type: none"> ○ “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”; ○ “Зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах” тухай; ○ “Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”; ○ “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх” журам батлах тухай; ○ Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж; ○ Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журам; ○ “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”; ○ “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”.
	ХАБЭА-н техникийн зохицуулалт, стандартууд

Хоёр. Нийт ажилтны сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго

- Бүх төрлийн ажлын байранд ажиллагсад нарт аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголтыг өгөхөд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2. Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, хандлага

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хүргэж болзошгүй аюулыг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай талаарх ерөнхий **ойлголт**
2. Мэргэжлээс шалтгаалсан өвчлөл үүсгэж болзошгүй ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай талаарх ерөнхий **ойлголт**
3. Хөдөлмөрийн болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх ерөнхий мэдлэг
4. Ажлын байран дахь осол, өвчлөлд хүргэж болзошгүй хүчин зүйлсийг илрүүлэх, мэдээлэх, арилгах арга хэмжээнд идэвхтэй оролцох хандлага

3. Сургалтад хичээл заах багшид тавигдах шаардлага

Заавал биелүүлэх шаардлага

- ХАБЭА-н талаарх мэдлэг, хандлагыг их дээд сургууль, төгсөлтийн дараах сургалт, ХАБЭА-н түр сургалтаар эзэмшсэн
- ХАБЭА-н практик ажлын 2-оос доошгүй жилийн туршлагатай

4. Сургалтын зохион байгуулалт

Анги танхим, ажлын байр, нэгж дээр зохион байгуулна.

5. Цагийн багтаамж: 13 цаг

6. Үнэлгээ

Дараахь шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно. Үүнд:

Ирц: Сургалтын бүх сэдвийн хичээлд суусан байх

Сорил: Эзэмшвэл зохих мэдлэгийн 80-аас багагүй хувийг эзэмшсэн нь сорилын шалгалтаар үнэлэгдсэн байх.

7. Сургалтын сэдэв

Д/д	Сэдэв	цаг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	1
2	Хөдөлмөрийн тухай хууль	2
3	ХАБЭА-н хууль	1
4	Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт	2
5	Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалсан өвчин /МШӨ/	1
6	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ	1
7	Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтан бүрийн үүрэг, оролцоо	1

8	Ажил эхлүүлэхээс өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй, практик дадлага	1
9	Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал	1
10	Осолд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	1
11	Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт	1
	Нийт	13

8. Сургалтын агуулга

Сэдэв	Агуулга
Сэдэв 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ойлголт, хамаарах асуудал
	Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай ойлголт, хамаарах асуудал
	Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн зорилго, ач холбогдол
Сэдэв 2. Хөдөлмөрийн тухай хууль	Хөдөлмөрийн гэрээ
	Хамтын гэрээ, хэлэлцээр
	Ажил амралтын цаг
	Цалин хөлс
	Бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлог, зохицуулалт
	Хөдөлмөрийн сахилга, дотоод журам
Сэдэв 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн зохицуулалт
	ХАБЭА-н талаарх иргэн, ажилтны эрх, үүрэг
Сэдэв 4. Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний тухай ойлголт, даатгал, тусламж, үйлчилгээ
	Аюул, эрсдлийн тухай ойлголт
	Ажлын байран дахь осолд хүргэдэг аюулын төрлүүд: <ul style="list-style-type: none"> ○ Ажлын байрны эмх цэгц ○ Хальтрах, бүдрэх, унах аюул ○ Цахилгааны аюул ○ Тоног төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой ○ Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой ○ Галын аюулгүй байдал ○ Химийн хортой ба аюултай бодисын хэрэглээ ○ Хязгаарлагдмал орчин ○ Өндөрт ажиллах ○ Ажлын оновчгүй зохион байгуулалт ○ Ажил гүйцэтгэх арга барил ○ Эргономикийн хүчин зүйлстэй холбоотой ○ Онцгой үеийн бэлэн байдал хангаагүйтэй холбоотой ○ Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөхгүй байх ○ Ажилтны эрүүл мэнд, биеийн байдал г.м.
	Ажлын байранд тохиолдсон үйлдвэрлэлийн ослын практик жишээнүүд
Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос сэргийлэх зохион байгуулалт, инженер технологи, хувь хүнд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ	

Сэдэв 5. Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалсан өвчин	Химийн хортой хүчин зүйлс: Эрдэсийн болон органик тооснууд, гагнуурын тоосонцор, кварц цахиур, асбест, дэгдэмхий органик нэгдлүүд, хорт хий, уурнууд гэх мэт
	Физикийн хүчин зүйлс: Чанга шуугиан, доргион, халууны стресс, орчны хүйтэн температур, цацраг идэвхит туяа, цахилгаан соронзон цацраг, гагнуурын туяа (хэт ягаан туяа) гэх мэт
	Биологийн хүчин зүйлс: Халдвартай хог хаягдал, бохир ус, халдвартай хүн, амьтантай ажиллах гэх мэт
	Эргономикийн хүчин зүйлс: Хүнд зүйл өргөх, нэг маягийн олон давтагдсан хөдөлгөөн, албадмал байрлалд ажиллах гэх мэт
	Түгээмэл тохиолддог МШӨ: Уушги тоосжих, тоостой холбоотой амьсгалын эрхтний өвчин, доргионы өвчин, шуугианы гаралтай сонсгол алдагдалт, химийн бодисын архаг, хурц хордлого, ажилтай холбоотой халдвар гэх мэт
	Эрүүл мэндэд аюултай хүчин зүйлсийн өртөлтөөс хамгаалах удирдлага зохион байгуулалт, инженер технологи, хувь хүнд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ
Сэдэв 6. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зорилго, ач холбогдол
	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд
	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зохистой хэрэглээ
Сэдэв 7. Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтан бүрийн үүрэг, оролцоо	Ажлын байранд эрсдлийн үнэлгээ хийх тухай
	Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэх аюулыг таньж илрүүлэх
	Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэх аюулыг холбогдох албан тушаалтанд мэдээлэх
	Ажлын байранд аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ
Ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ослыг тэглэхэд ажилтны гүйцэтгэх үүрэг, оролцоо	
Сэдэв 8. Ажил эхлүүлэхээс өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй, практик дадлага	Ажил эхлүүлэхийн өмнөх эрсдэлийн үнэлгээний ач холбогдол, хэрэглээ
	Ажил эхлүүлэхээс өмнө ажлын байранд осол, өвчлөл үүсгэж болзошгүй аюулыг илрүүлж, эрсдлийг үнэлэх
	Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн ажил эхлүүлэхтэй холбоотой шийдвэрийг гаргах арга
Сэдэв 9. Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал	Онцгой байдлын тодорхойлолт, хамрах хүрээ
	Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээний дэс дараа
Сэдэв 10. Осолд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	Эмнэлгийн анхны тусламжийн тодорхойлолт, хамаарах асуудал
	Анхны тусламжийн иж бүрдэл, түүний хэрэглээ
	Ослын газарт нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ
	Осолд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж
Сэдэв 11. Ажилтны зан үйлтэй	Хувь хүний зан үйлтэй холбоотой үүсдэг халдвар бус өвчнүүд: Таргалалт, зүрх судасны өвчин, артерийн даралт ихсэлт,

холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт	чихрийн шижин, хоол боловсруулах эрхтний өвчнүүд
	Халдварт бус өвчин үүсгэхэд нөлөөлдөг зан үйлүүд: Согтууруулах ундаа, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, чихрийн их хэрэглээ, зохисгүй хооллолт
	Эрүүл зан үйлийг дадал болгох тухай ойлголт

Гурав. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго

- Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан ажиллахад шаардлагатай онолын суурь мэдлэг, хандлага, дадлыг эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

2. Сургалтыг дүүргэснээр эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлага

Мэдлэг:

- Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлсийн шинж чанар, тэдгээрээс үүсэх осол, хордлого, өвчний талаарх суурь мэдлэг;
- Ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалтын зохион байгуулалтын талаарх ерөнхий ойлголт;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг;
- Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн бүтэц, зохион байгуулалтын талаарх суурь мэдлэг;
- ХАБЭА-н хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын талаарх ойлголт;

Чадвар:

- ХАБЭА-н үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартыг мөрдөж ажиллах;
- ХАБЭА-н талаарх байгууллагын журам, баримт бичгийг боловсруулах;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгцээг тодорхойлох;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг үүсгэх аюул, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлсийн удирдлага, холбогдох албан тушаалтан, нийт ажилтанд үнэн зөвөөр тохиромжтой арга хэлбэрээр таниулан ойлгуулах сургалт, зааварчилгаа, аюулыг мэдээлэх харилцааг үр дүнтэй зохион байгуулах;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр нөлөөг нь үнэлэх;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг судлан бүртгэх, шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх;
- Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалтад хяналт тавих;

Хандлага:

- Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ёс зүйтэй, хуулийн хүрээнд ажиллах;
- ХАБЭА-н үйл ажиллагааг урьдчилан сэргийлэлтэд суурилсан зарчмаар хэрэгжүүлэх;
- ХАБЭА-н үйл ажиллагааг нотолгоо баримтад үндэслэн төлөвлөн, үнэлэх;

3. Сургалтад хичээл заах багшид тавигдах шаардлага

Эмнэлгийн анхны тусламж, Ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалтын хичээлийг тус чиглэлээр мэргэшсэн эмч заана.

4. Сургалтын зохион байгуулалт:

Сургалтыг танхимд болон дадлагын талбарт зохион байгуулна.

5. Заавал судлах хичээлийн цагийн багтаамж: 124 цаг

6. Хичээлийн сэдэв

Д/д	Сэдэв	цаг
Заавал судлах хичээл		
1	ХАБЭА-н удиртгал хичээл	2
2	ХАБЭА-н хууль эрх зүй	8
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал	20
4	Хөдөлмөрийн эрүүл ахуй	18
5	ХАБЭА-н сургалт, зааварчилгаа	10
6	Аюулгүй ажиллагааны эрсдэлийн менежмент	12
7	Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, тавигдах шаардлага	10
8	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх	10
9	Аюулыг илрүүлэх, мэдээлэх харилцаа	10
10	Онцгой байдлын үеийн аюулгүй ажиллагаа	4
11	Хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	10
12	ХАБЭА-н менежментийн тогтолцоо	10
	Нийт	124
Сонгон суралцах хичээл		
1	Эргономикийн үндэс	14
2	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээ	36
3	Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт	16
4	Химийн хортой, аюултай материалын аюулгүй байдал	12
5	Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн менежмент	20
6	Ажлыг аюулгүй гүйцэтгэх үндсэн алхам, аюулгүй ажиллах 10 дүрэм	
7	Гар багажны аюулгүй ажиллагаа	
8	Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	
	Нийт	

7. Заавал судлах хичээлийн агуулга

Модуль 1. ХАБЭА-н удиртгал хичээл

Д/д	Сэдэв	цаг
1	ХАБЭА-н талаарх хууль тогтоомж ХАБЭА-н удирдлагын тогтолцоо /бодлогын түвшинд/	1
2	ХАБЭА-н ажилтны үүрэг, ёс зүйн асуудал	1
	Нийт	2

Модуль 2. ХАБЭА-н хууль эрх зүй

Д/д	Сэдэв	цаг
1	Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журам	1
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохицуулсан хууль, дүрэм, журам	1
3	Нийгмийн даатгал, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт	1
4	ХАБЭА-н талаар мөрдөх журам, техникийн зохицуулалт, стандарт, зөвлөмж	2
5	Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н бүтэц, зохион байгуулалт болон ажилтан, зөвлөл ажиллуулах эрх зүйн зохицуулалт	1
6	Ажлын байранд эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт	1
7	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг	1

	бүртгэх, мэдээлэх асуудлын тухай эрх зүйн зохицуулалт	
	Нийт	8

Модуль 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал

Д/д	Сэдэв	цаг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт	1
2	Үйлдвэрлэлийн суурь машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал	2
3	Цахилгааны аюулгүй ажиллагаа	2
4	Галын аюулгүй байдал	2
5	Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа	2
6	Барилгын аюулгүй ажиллагаа	2
7	Өндрийн аюулгүй ажиллагаа	2
8	Даралтат хий, савны аюулгүй ажиллагаа	2
9	Материал, түүхий эдтэй харьцах ажиллагаа	2
10	Ухалт малталтын аюулгүй ажиллагаа	1
11	Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, аюултай хүчин зүйлсийн ангилал	1
12	Түгжих, пайзлах (Lockout and Tag out)	1
	Нийт	20

Модуль 4. Хөдөлмөрийн эрүүл ахуй

Д/д	Сэдэв	цаг
1	Хөдөлмөрийн эрүүл ахуйн суурь ойлголт	2
2	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	1
3	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийн арга зүй	2
4	Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ	1
5	Ажлын байрны агаар дахь тоос, хорт бодисын өртөлт, тэдгээрээс шалтгаалсан өвчлөлийн урьдчилан сэргийлэлт	2
6	Ажлын байран дахь физикийн хүчин зүйлсийн өртөлт, тэдгээрээс шалтгаалсан өвчлөлийн урьдчилан сэргийлэлт: доргион, шуугиан, ионжуулагч цацраг, бичил цаг уур, дулааны стресс	2
7	Эргономик	2
8	Ажлын байран дахь биологийн аюултай хүчин зүйлс, өртөлтөөс урьдчилан сэргийлэх зарчим	1
9	Хор судлалын тухай ерөнхий ойлголт, хөдөлмөрийн эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	1
10	Химийн хортой ба аюултай бодисын ангилал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, хор аюулын лавлах мэдээлэл	2
11	Хөдөлмөрийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний эрэмбэ: техник технологи, удирдлага зохион байгуулалт хувь хүнд чиглэсэн	2
	Нийт	18

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 5. ХАБЭА-н сургалт, зааварчилгаа

Д/д	Сэдэв	цаг
1	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах*	1
2	Сургалтын хэрэглэгдэхүүн /конспект, гарын авлага, материал/ боловсруулах*	2
3	Сургалтын зохион байгуулалт, заах арга зүй*	4
4	ХАБЭА-н анхан шатны зааварчилгаа өгөх *	3
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ

Модуль 6. Аюулгүй ажиллагааны эрсдэлийн менежмент

Д/д	Сэдэв	цаг
1	Ажлын байрны эрсдэлийн тухай ойлголт. Эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ,	2

	менежмент	
2	Эрсдэл, эрсдэлийн менежменттэй холбоотой олон улсын стандартууд тэдгээрийн хэрэглээ	2
3	Аюул, аюулын ангилал, шалтгаан. Техникийн, ажилтны болон зохион байгуулалтын нөлөөлөл	2
4	Эрсдэлийг тодорхойлох аргууд, тэдгээрийн оновчтой хэрэглээ	2
5	Эрсдэлийг үнэлэх үзүүлэлтүүд, эрсдэлийн зөвшөөрөх түвшин	2
6	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулах*	1
7	Эрсдэлийг арилгах, бууруулах арга хэмжээнд дүн шинжилгээ хийх арга*	1
	Нийт	12

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 7. Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, тавигдах шаардлага

Д/д	Сэдэв	цаг
1	Хувийн хамгаалах хэрэгслийн талаар суурь ойлголт, тавигдах шаардлага	1
2	Нүд, нүүр хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага	1
3	Амьсгал хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага	2
4	Сонсгол хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага	1
5	Толгой, гар, хөл хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага	1
6	Ажилтнуудын хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох, тохиромжтой байдал, үр нөлөөг үнэлэх*	2
7	Ажилтнуудад зориулсан ХХХ-ийн хэрэглээний талаарх сургалт зааварчилгаа*	2
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого /ҮОХХ/-г судлан бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх

Д/д	Сэдэв	цаг
1	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын ойлголт, түүнийг судлан бүртгэх, дүн шинжилгээ хийх ач холбогдол, зорилго	1
2	ҮОХХ-ын тохиолдлыг судлан бүртгэх, дүн шинжилгээ хийх ажлын зохион байгуулалт, дүн шинжилгээ эхлүүлэх*	2
3	ҮОХХ-ын талаарх баримт мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх, шалтгаан, хүчин зүйлийг тогтоох*	4
4	ҮОХХ-ын шалтгааныг арилгах, дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах*	2
5	ҮОХХ-ыг тогтоосон акт, бүрдүүлэх баримт бичиг, баталгаажуулалт	1
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 9. Аюулыг илрүүлэх, мэдээлэх харилцаа

Д/д	Сэдэв	цаг
1	Аюулыг илрүүлэх, мэдээлэх харилцааны тухай ойлголт	1
2	Ажлын байранд дүн шинжилгээ хийх аюулыг мэдээлэх харилцааны хэрэгцээг тодорхойлох*	2
3	ХАБЭА-н тэмдэг, тэмдэглэгээний ангилал	1
4	ХАБЭА-н аюулыг мэдээлэх арга, хэлбэрүүд*	2
5	Аюултай бараа, материалын шошго, тэмдэглэгээ*	2
6	Хор аюулын лавлах мэдээлэл*	2
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 10. Онцгой байдлын үеийн аюулгүй ажиллагаа

Д/д	Сэдэв	цаг
-----	-------	-----

1	Онцгой байдлын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, журам	1
2	Ажилтнуудад зориулсан сургалт, бэлтгэл хангах	1
3	Онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө	1
4	Онцгой байдлын үеийн бэлэн байдлыг үнэлэх, хяналт тавих	1
	Нийт	4

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ

Модуль 11. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Д/д	Сэдэв	цаг
1	Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төрлүүд	1
2	Ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн зохион байгуулалт	1
3	Ажилтны эрүүл мэндэд тавигдах шаардлага, ажил хөдөлмөрийн тохирол	1
4	Түгээмэл тохиолддог мэргэжлээс шалтгаалсан өвчнүүд	2
5	Анхны тусламжийн иж бүрдэл, түүний бэлэн байдал	1
6	Осолдогчид үзүүлэх анхны тусламж	1
7	Зүрхний ажиллагаа зогсох үед үзүүлэх анхны тусламж*	1
8	Амьсгалын үйл ажиллагаа алдагдсан үед үзүүлэх анхны тусламж*	1
9	Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж*	1
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Модуль 12. ХАБЭА-н менежментийн тогтолцоо

Д/д	Сэдэв	цаг
1	Байгууллагын ХАБЭА-н менежментийн бүтэц, зохион байгуулалт	2
2	ХАБЭА-н талаар байгууллагын бодлого, удирдлагын манлайлал, ажилтны оролцоо	2
3	ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн үнэлгээ, санхүүжилт*	2
4	ХАБЭА-н гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод хяналт шалгалт	2
5	ХАБЭА-н менежментийн олон улсын сайн туршлага	2
	Нийт	10

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Дөрөв. ХАБЭА-н сургагч багшийн сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго:

- Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н ажилтан болон ХАБЭА-н асуудлаар мэргэшсэн, туршлагатай ажилтанд заан сургах болон сургалт явуулахад шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2. Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, чадвар

Мэдлэг:

- ХАБЭА-н зайлшгүй мэдэх үндсэн ойлголт;
- Багшийн төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр гаргах аргачлалын талаарх суурь мэдлэг;
- Насанд хүрэгсдийн боловсрол, сэтгэл зүйн онцлогийн талаарх ерөнхий ойлголт;
- ХАБЭА-н асуудлаар сургалт явуулахад зайлшгүй шаардлагатай арга зүйн мэдлэг;
- Түгээмэл тохиолдох үйлдвэрлэлийн осол болон хөдөлмөрийн эрүүл ахуйн кейс дээр ажиллах мэдлэг

Чадвар:

- Суралцагчдын хэрэгцээнд үндэслэн сургалтыг төлөвлөн, хэрэгжүүлэх;
- Сургалтыг үр дүнтэй төлөвлөн, зохион байгуулах;
- Сургалтын хэрэгцээг тодорхойлон сургалтын материал боловсруулах;
- Заах, илтгэх үр чадвар;
- Суралцагдыг зохистой үнэлэх;

3. Сургалтад хичээл заах багшид тавигдах шаардлага:

Заавал биелүүлэх шаардлага

-

4. Сургалтын зохион байгуулалт:

Сургалтыг танхим болон дадлагын талбарт зохион байгуулна.

5. Цагийн багтаамж: 40 цаг

Сургалтын үргэлжлэх хугацаа 40 минут

6. Үнэлгээ:

7. Сургалтын сэдэв

Д/д	Сэдэв	цаг
1	ХАБЭА-н удиртгал хичээл	4
2	Ажлын байранд аюулыг илрүүлэх, үнэлэх, хянах олон улсын сайн туршлага	3
3	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тулгамдсан асуудал, түгээмэл тохиолдох үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол	1
4	Хөдөлмөрийн эрүүл ахуйн тулгамдсан асуудал, түгээмэл тохиолдох мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол	1
5	Насанд хүрэгсдийн боловсрол, сэтгэл зүйн онцлог	4
6	Сургалтын хэрэгцээг тодорхойлох	1
7	Хичээлийн хөтөлбөр боловсруулах	2
8	Сургалтын арга, хэлбэр	2

9	Заах арга зүй	2
10	Багшийн манлайлал /имиж бүрдүүлэлт/	4
11	Сургалтын үнэлгээ	2
12	Багшийн төлөвлөгөө гаргах	2
13	Конспект, материал бэлтгэх*	4
14	Багшлах дадлага	4
15	Илтгэлийн нэгдсэн үнэлгээ	4
	Нийт	40

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ.

Тав. ХАБЭА-н тусгай сургалтын хөтөлбөр

№	Чиглэл	цаг
1.	Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	16
2.	Өргөх, зөөх, тээвэрлэх механизм /ӨЗТМ/-тай харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	22
3.	Ионжуулагч цацрагийн аюулгүй ажиллагаа	18
4.	Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	26
5.	Биологийн халдвартай хог хаягдал, материалтай харьцах аюулгүй ажиллагаа	23
6.	Тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	12
7.	Температурын эрс тэс нөхцөлд ажиллах аюулгүй ажиллагаа	14
8.	Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	16
9.	Хязгаарлагдмал орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	16
10.	Далд уурхайн аюулгүй ажиллагаа	16
11.	Ил уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа	18
12.	Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа	16
13.	Цахилгааны аюулгүй ажиллагаа	12
14.	Галын аюулгүй байдал	14
15.	Барилгын аюулгүй ажиллагаа	20
16.	Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан аюулгүй ажиллагаа	16
17.	Мал аж ахуйн аюулгүй ажиллагаа	18
18.	Тээврийн аюулгүй ажиллагаа	8
19.	Анхны тусламжийн сургалт	30

Нэг. Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Даралтат савын төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм	2
2	Уур халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм	2
3	Баллонд тавигдах шаардлага, аюулгүй ажиллагаа	2

4	Даралтат савны гагнуур, дулааны боловсруулалтын аюулгүй ажиллагаа	2
5	Даралтат сав, уур, халуун усны хоолой, баллоны үндсэн хийц, элементүүдийн техникийн байдлын хяналт	4
6	Даралтат сав, уур, халуун усны хоолойд хийсэн гагнуурын ажлын чанарын хяналт, үнэлгээ	4
	Нийт	16

Хоёр. Өргөх, зөөх, тээвэрлэх механизм /ӨЗТМ/-тай харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	ӨЗТМ-ын нэр төрөл, бүтэц зохион байгуулалт, онцлогууд	2
2	ӨЗТМ-ын аваар ослоос хамгаалах хэрэгслүүд тэдгээрт тавих хяналт	2
3	Оосорлох хэрэгслүүд, тэдгээрт тавигдах шаардлага, хяналт	2
4	Үйлдвэрлэлд ӨЗТМ ашиглах үеийн аюулгүй хүчин зүйлүүд, эрсдэлийн үнэлгээ	2
5	ӨЗТМ-н техникийн байдал, аюулгүй ажиллагааг хянах техник технологи, түүний хэрэглээ	4
6	ӨЗТМ-ын аюулгүй ажиллагаа хариуцагчийн үүрэг техник зохион байгуулалт, засвар угсралт	2
7	ӨЗТМ-ын засвар угсралтын ажлын төлөвлөлт зохион байгуулалт, засвар угсралтын ажлын дараах хяналт	4
8	ӨЗТМ-ын цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа	2
	Нийт	20

Гурав. Ионжуулагч цацрагийн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Ионжуулагч цацрагийн тухай ерөнхий ойлголт	2
2	Ионжуулагч цацрагийн хэрэглээ: Үйлдвэрлэл, хяналт шалгалт, анагаах ухаан	2
3	Ионжуулах цацрагаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл	2
4	Ионжуулагч цацрагийн өртөлтийн тунг хэмжиж хянах аргууд	2
5	Цацрагийн аюулгүй байдлыг хангах үндсэн зарчим	4
6	Ионжуулагч цацрагт өртөн ажиллагсадын эрүүл мэндийн тандалт	2
7	Ионжуулагч цацрагийн аюулгүй байдлын талаарх Монгол улсын хууль эрх зүйн зохицуулалт	4
	Нийт	18

Дөрөв. Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль, дүрэм, журам, ОУХБ-ын 170-р конвенц	1
2	Ажлын байранд ашиглахыг зөвшөөрсөн химийн хорт бодисын хор аюулын талаар	1

3	Хор судлалын ерөнхий ойлголт	2
4	Химийн бодисын таних тэмдэг, ангилал, хаяг шошго	2
5	Аюултай бодисыг шошголох, ангилах, бэлтгэхэд тавигдах ерөнхий шаардлага	2
6	Химийн бодисын өртөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэхэд ашиглагддаг зөвшөөрөгдөх дээд хэмжээний талаарх ойлголт	2
7	Аюултай бараа материалыг зөөвөрлөхөд мөрдөх НҮБ-ын зөвлөмж	2
8	Химийн бодисын аюулгүй байдлын мэдээллийн лавлах	2
9	Химийн хорт ба аюултай бодисын тээвэрлэлт, хадгалалт	2
10	Уусгагчдын шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө	2
11	Металлын шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө	2
12	Хорт хийнүүд, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө	2
13	Химийн осолд хүргэх эрсдэлтэй аюултай бодис	2
14	Химийн бодисын бүртгэл, менежмент	2
	Нийт	26

Тав. Биологийн халдвартай хог хаягдал, материалтай харьцах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Биологийн аюултай хүчин зүйлсийн ангилал, шинж чанар: Бактери, мөөгөнцөр, вирус, шимэгч, генетикийн өөрчлөлттэй бичил биетэн	4
2	Микробиологийн эрсдэлийн үнэлгээ	2
3	Био-аюулгүй байдлын зэрэглэлийн тодорхойлолт, ангилал	2
4	1, 2-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт, тоног төхөөрөмж, ажилтнуудад тавигдах эрүүл мэндийн тагдалт, сургалт, хог хаягдал, хими, гал, цахилгаан, цацраг, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал	4
5	3-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт, тоног төхөөрөмж, ажилтнуудад тавигдах эрүүл мэндийн тандалт	4
6	4-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт	2
7	Лабораторийн амьтантай харьцах үеийн аюулгүй ажиллагаа: 1, 2, 3, 4-р түвшний Био-Аюулгүй байдал	2
8	Лабораторийн аюулгүй байдлын менежмент	2
9	Биологийн аюултай хүчин зүйлсийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомж	1
	Нийт	23

Зургаа. Тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Үйлдвэрлэлийн процессын аюулгүй ажиллагаа. MNS 4968:2000 ХАБЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	1

2	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	1
3	Машин тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, үндсэн зарчим	2
4	Машин тоног төхөөрөмжийн аюул болон эрсдэлийн хяналт	1
5	Машин тоног төхөөрөмжийн техникийн байдлын хяналт	1
6	Тоног төхөөрөмжийн зүгээс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйд нөлөөлж буй хүчин зүйл	2
7	Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал ба тандалт	2
8	Машин тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын иж бүрэн үнэлгээ	2
	Нийт	12
	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны баталгаажилт, техник ашиглалтын паспорт, заавар	

Долоо. Температурын эрс тэс нөхцөлд ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Цаг уурын эрс тэс нөхцөлийн тухай ойлголт	2
2	Дулааны стресс бүхий ажлын нөхцөл орчин	2
3	Дулааны стрессийг үнэлэх аргууд	2
4	Дулааны стрессийн урьдчилан сэргийлэлт	2
5	Хүйтний стрессийн нөлөө	2
6	Хүйтний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөлөө	2
7	Орчны эрс тэс температурт ажиллагчдын эрүүл мэндийн тандалт	2
	Нийт	14

Найм. Өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Өндөрт ажиллах үеийн аюултай хүчин зүйлс, тэдгээрийг таньж илрүүлэх арга*	2
2	Өндрийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх*	4
3	Өндрөөс унахаас сэргийлэх хэрэгсэл, үзлэг шалгалт	2
4	Унахаас сэргийлэх. Суурин бэхэлгээтэй ажлын тавцан, сагстай өргөгч, өргөх хайрцгийг аюулгүй ашиглах	1
5	Барилгын шат, задгай ирмэгийн хамгаалалт, хязгаарлах хэрэгсэл ба унахаас хамгаалах систем	1
6	Өндрөөс унаж буй биетийг хянах	1
7	Өндөрт гүйцэтгэх ажлыг багасгах инженерийн шийдэл, цогц арга хэмжээ	1
8	Өндөрт аврах ажиллагаа явуулах*	2
9	Өндөрт ажиллах ажилтнуудад зориулсан сургалт*	2
	Нийт	16

* Тухайн сэдвээр практик дадлага хийнэ

Ес. Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Хязгаарлагдмал орчны тодорхойлолт, аюулууд.	1
2	Хязгаарлагдмал орчинд мөрдөх аюулгүй ажиллагааны журам	1
3	Хязгаарлагдмал орчны аюулыг илрүүлэх, хяналт тавих арга хэмжээ*	2

4	Хязгаарлагдмал орчинд нэвтрэх, ажиллах зөвшөөрөл олголт*	2
5	Хязгаарлагдмал орчны агаарын бохирдлын шинжилгээ, хяналт. Агаарын мониторингийн төхөөрөмж	1
6	Хязгаарлагдмал орчны цэвэрлэгээ ба ариутгал. Хязгаарлагдмал орчны агааржуулалт	2
7	Хязгаарлагдмал орчинд ашиглах аюулгүйн тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл	1
8	Зөөврийн цахилгаан төхөөрөмж, шингэн болон хийт төхөөрөмжийн ашиглалт	2
9	Хязгаарлагдмал орчинд ажиллах болон аврах багт тавигдах шаардлага, гүйцэтгэх үүрэг*	2
10	Хязгаарлагдмал орчинд нэвтэрч ажиллах ажилтнуудад хийх сургалт*	2
	Нийт	16

Арав. Далд уурхайн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Далд уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс	2
2	Уул уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд. Далд уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм -н танилцуулга	1
3	Үйлдвэрлэлийн процессын аюулгүй ажиллагаа. MNS 4968:2000 ХАБЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	1
4	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	1
5	Далд уурхайн өрөмдлөгийн ажлын үеийн аюулгүй ажиллагаа. Малталт, нэвтрэлт, бэхэлгээний ажлын аюулгүй ажиллагаа	2
6	Далд уурхайн тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагаа	1
7	Далд уурхайн ухаж ачих ажлын аюулгүй ажиллагаа	1
8	Далд уурхайн тээврийн ажлын аюулгүй ажиллагаа	1
9	Уурхайн өргөн тээвэрлэх машины аюулгүй ажиллагаа	1
10	Туслах ажлын аюулгүй ажиллагаа	1
11	Нуралт, цөмрөлтөөс үүсэх аюул. Урьдчилан сэргийлэх, мониторинг хийх	1
12	Далд уурхайн агааржуулалт. Хортой хийн аюулгүй ажиллагаа	1
13	Гүний усны аюулгүй ажиллагаа	1
14	Гал, тэсрэх дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагаа	1
	Нийт	16

Арван нэг. Ил уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Ил уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс	2
2	Уул уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-н танилцуулга	1
3	Үйлдвэрлэлийн процессын аюулгүй ажиллагаа. MNS 4968:2000 ХАБЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	1

4	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	1
5	Уурхайн өрөмдлөгийн ажлын үеийн аюулгүй ажиллагаа	2
6	Уурхайн тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагаа	2
7	Уурхайн ухаж ачих ажлын аюулгүй ажиллагаа	2
8	Уурхайн тээврийн ажлын аюулгүй ажиллагаа	1
9	Овоолгын ажлын аюулгүй ажиллагаа	1
10	Туслах ажил, суурин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	1
11	Уурхайн хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зөөвөр, нүүдлийн аюулгүй ажиллагаа	1
12	Уурхайн мөрөгцөг, овоолгын гулсалт нурлаас үүдэх аюулгүй ажиллагаа	1
13	Уурхайн ус таталт, шүүрүүлэлтийн ажлын аюулгүй ажиллагаа	1
14	Уурхайн гал, тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагаа	1
	Нийт	18

Арван хоёр. Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Баяжуулах үйлдвэрлэлийн технологийн үндэс	2
2	Баяжуулах үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд.	1
3	Үйлдвэрлэлийн процессын аюулгүй ажиллагаа. MNS 4968:2000 ХАБЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	1
4	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	1
5	Урвалж химийн бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	2
6	Баяжуулах үйлдвэрийн дотоод тээвэр, түүнд тавигдах шаардлага	1
7	Баяжуулах үйлдвэрийн процессийн аюулгүй ажиллагаа. Хөвүүлэн баяжуулалт, соронзон ба цахилгаан баяжуулалт, Хүхэрлэг хүдрийг баяжуулахад тавигдах нэмэлт шаардлагууд, Рентген, хэт ягаан долгионы тусламжтайгаар хүдэр ялгах төхөөрөмжид тавигдах шаардлага. Хүндийн хүчний баяжуулалт.	2
8	Баяжуулалтын туслах процессийн аюулгүй ажиллагаа. Өтгөрүүлэлт, шүүх, ууршуулах процесс, зуух, хатаах процессийн аюулгүй ажиллагаа	2
9	Хаягдлын аж ахуйн аюулгүй ажиллагаа	1
10	Гидрометаллургийн процессийн аюулгүй ажиллагаа. Бага, өндөр даралтын тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, Овоолгын уусгалтын аюулгүй ажиллагаа	1
11	Хүдэр, баяжмал, хүдрийн бус материалын агуулахын үйл ажиллагаа	1
12	Бөөнцөглөх, ангижруулах, шатаах, хатаах процессийн аюулгүй ажиллагаа	1
13	Гал, тэсрэх дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагаа	1
	Нийт	17

Арван гурав. Цахилгааны аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Үйлдвэрийн цахилгааны аюулгүй ажиллагааны судлах зүйл, шийдвэрлэх асуудлууд. Үндсэн ойлголт, нэр томъёо, тодорхойлолтууд	1
2	Цахилгаан гүйдлийн аюул. Цахилгааны осол. Цахилгааны ослын хүндрэлийн байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд	2
3	Тусгаарлагдсан саармагтай болон шууд газардуулсан гурван фазын цахилгаан сүлжээний аюултай байдал	1
4	Нэг фазын сүлжээний аюултай байдал, схемийн онцлогууд	1
5	Цахилгаан гүйдэл газардах үзэгдэл. Хүрэх хүчдэл. Алхамын хүчдэл.	1
6	Үйлдвэрлэлийн болон ажлын байр, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний цахилгааны аюулгүй ажиллагааны нөхцөл, тэдгээрийн ангилал	1
7	Цахилгаан тоног төхөөмжийн ашиглалтын үеийн хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн ялгаа, онцлог, хэрэглэх хүрээ	1
8	Цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжийн тусгаарлал, цахилгаан тусгаарлалын байдалд тавих хяналтын техник, зохион байгуулалтын арга хэмжээ	1
9	Бага хүчдэл хэрэглэх. Цахилгааны аюулгүй ажиллагааны хориг түгжээ.	1
10	Хамгаалах газардуулга, газардуулгын байгууламжийн бүтэц, хийц. Хамгаалах газардуулгын тооцоо, үзлэг, хяналт, хэмжилт.	1
11	Нойлтуулга, түүний бүтэц, хийц. Нойлтуулгын тооцоо, хяналт.	1
12	Хамгаалах таслалт, түүнийг хэрглэх хүрээ. Хамгаалах таслалтын схемүүд	1
13	Цахилгаанаас хамгаалах хэрэгсэл, тэдгээрийн ялгаа, ангилал, хэрэглэх хүрээ. Цахилгааны аюулгүй ажиллагааны анхааруулах, хориглох, зөвшөөрөх, сануулах плакат.	1
14	Цахилгаан техникийн ажилтанд тавих шаардлага. Цахилгааны аюулгүй ажиллагааны мэргэшлийн групп. Цахилгааны осолд орсон хүнийг хүчдэлээс чөлөөлөх, осолдогчийн биеийн байдлыг тодорхойлох, анхны тусламж үзүүлэх	1
	Нийт	15

Арван дөрөв. Галын аюулгүй байдал

№	Сэдэв	цаг
1	Галын аюулгүй байдлыг хангахад тавигдах ерөнхий шаардлага, хууль тогтоомж	2
2	Байгууллагын галын аюулгүй байдлыг тодорхойлох шаардлага, норм, норматив. Гал түймрийн улсын хяналт	2
3	Байгууллагын гал түймрийн эрсдэлийг үнэлэх арга зүй. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2
4	Аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулаас хамгаадах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал. Галын аюулаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүний үүрэг /ажилтан, алба хаагчид, үйлчлүүлэгч иргэдийг гүүн шилжүүлэх ажиллагаа/, аюулгүй ажиллагаа	2
5	Галын аюулын зарлан мэдээллийн систем, холбоо, зохион	1

	байгуулалт	
6	Төрөл бүрийн гал түймрийг унтраах арга зүй /шатамхай хий, шингэн, хатуу бодис материал, цахилгаан эрчим хүчний барилга, тоног төхөөрөмж, үйлдвэр, үйлчилгээний газар, албан тасалгаа, гэр, байшин/. Гал унтраагуурын төрөл, ашиглалт. Утаат орчинд анхаарах асуудал*	3
7	Түлэгдэлт ба угаарын хийн хордолтын тухай ойлголт, түүнд үзүүлэх анхны тусламж*	2
	Нийт	14

* Тухайн сэдвээр дадлага хийнэ

Арван тав. Барилгын аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Барилгын ажлын талбайн аюулгүй ажиллагааг хангах ажлын зохион байгуулалт, үндсэн шаардлагууд	2
2	Аюулыг илрүүлэх, хяналт тавих арга хэмжээ	2
3	Тээвэрлэх, өргөн тээвэрлэх ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлага	1
4	Цахилгаан ба хийн гагнуур, хийгээр зүсэх ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлага	1
5	Нураалт, буулгалтын ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
6	Газар шорооны ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
7	Өрөмдлөгийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
8	Зуурмаг бэлтгэх ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
9	Угсралтын ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
10	Өргийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
11	Заслын ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
12	Мужааны ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
13	Тусгаарлалтын ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
14	Дээврийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
15	Инженерийн шугам сүлжээ, байгууламжийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
16	Тоноглол ба хоолой турших ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
17	Цахилгаан монтаж, тохируулга, холбоо дохиоллын ажлын аюулгүй ажиллагааны шаардлага	1
18	ХХХ-ийн хэрэглээний талаар сургалт, зааварчилгаа*	2
	Нийт	21

Арван зургаа. Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт	1
2	Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	1
3	Монгол Улсад мөрдөж буй ХАБЭА-н талаарх хууль эрх зүйн	2
4	Монгол Улс дахь ХАБЭА-н удирдлагын тогтолцоо	1
5	Байгууллагын ХАБЭА-н журам боловсруулахад тавигдах шаардлага	2
6	Үйлдвэрлэлийн ослын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	2

7	Мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	2
8	Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалтын зарчим	1
9	ХАБЭА-н менежментийн тогтолцоо	2
10	Бичил бизнесийн ХАБЭА-н менежментийн практик жишээ	2
	Нийт	16

Арван долоо. Мал аж ахуйн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Мал аж ахуйтай холбоотой ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс	4
2	Мал амьтнаас хүнд халдар халдварт өвчний урьдчилан сэргийлэлт	4
3	Орчны эрс тэс температурын сөрөг нөлөө, түүний урьдчилан сэргийлэлт	2
4	Байгаль, цаг уурын эрсдэлтэй нөхцөлд ажиллах бэлэн байдал /гамшгийн/	2
5	Мал амьтантай харьцах үеийн ослын урьдчилан сэргийлэлт: Мал амьтанд хазуулах, мориноос унах	2
6	Эмнэлгийн анхны тусламж	2
7	Малчдын эрүүл мэндийн үзлэг тандалт, НЭМ-ийн тусламж үйлчилгээ	2
	Нийт	18

Арван найм. Тээврийн аюулгүй ажиллагаа

№	Сэдэв	цаг
1	Ачаа тээвэрлэлтэнд тавигдах үндсэн шаардлага, нөхцөл. Аюулгүй ажиллагааны холбогдох хууль эрх зүйн баримт бичиг	1
2	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. MNS 4930:2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	2
3	Тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага, хангалт.	1
4	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт. Хөдөлгөөн эхлүүлэх, парклах, ачаа ачих үеийн аюулгүй ажиллагаа	2
5	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн болон ажиллах чадварын хяналт. Засвар үйлчилгээний ажлын үеийн аюулгүй ажиллагаа	2
	Нийт	8

Арван ес. Анхны тусламжийн сургалт

№	Сэдэв	цаг
1	Өвчтөний биеийн байдлыг үнэлэх үндсэн үнэлгээний зарчим (ABCD-primary survey), амилуулах суурь тусламж	4
2	Өвчтөний биеийн байдлыг үнэлэх лавшруулсан арга (secondary survey)	2
3	Яаралтай тусламжийн эрэмбэлэн төрөлжүүлэлт	4
4	Хүнд өвчтөний биеийн байдлыг мэдээлэх зарчим, ЯТ-ийн дуудлага өгөх, хүлээн авах дэслэл, олон улсын ISBAR зарчим	2
5	Яаралтай тусламжийн өрөө, цүнх, иж бүрдэл, эмүүдийг хэрэглэх	4

6	Амьсгалын зам чөлөөлөх хэрэглэлүүдийн тусламжтай АЗ чөлөөлөх аргууд, гар амьсгуураар амьсгалуулах аргачлал	4
7	Осолдогчдод тусламж үзүүлэх ABCDE дэслэл	2
8	Дефибрилляци хийх аргачлал	4
9	Өвчтөнийг ослын бүсээс холдуулах, хүнд өвчтөний тээвэрлэлт	2
10	Цочмог өвдөлтийн үед үзүүлэх суурь тусламж	2
	Нийт	30

Зургаа. Олон нийтийн сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго:

- орчин үеийн аюултай хүчин зүйлсээс хүн, нийгмийг хамгаалах үндсийг мэдэж, энэхүү мэдлэгийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэгтэй зөв иргэнийг төлөвшүүлэх,
- эх оронч үзэл, суурин соёл иргэншил, нийгэмд хүлээх хариуцлагын боловсрол олгох,
- эрүүл амьдралын хэв маягийн үндсийг судалж, эзэмших,
- орчин үеийн өдөр тутмын амьдрал, аюултай нөхцөл, онцгой байдлын үед хүнд учрах аюул, занал, түүнээс хамгаалах арга, техникийг судлах.

2. Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, чадвар

Мэдлэг:

-

Чадвар:

-

3. Сургалтад хичээл заах багшид тавигдах шаардлага:

Заавал биелүүлэх шаардлага

-

4. Сургалтын зохион байгуулалт:

Сургалтыг анги, танхимд зохион байгуулна.

5. Цагийн багтаамж: 36 цаг

6. Үнэлгээ:

7. Сургалтын сэдэв

Д/д	Сэдэв	цаг
1	Галаас урьдчилан сэргийлэх	5
2	Эд зүйлээ хамгаалах, танихгүй хүнтэй харилцах	5
3	Гэртээ мөрдөх дүрэм	13
4	Угаарын хий, үзүүлэх тусламж	2
5	Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлийн үед авах арга хэмжээ	3
6	Байгальд мөрдөх аюулгүй байдлын асуудал	8
	Нийт	36

8. Сургалтын агуулга

Сэдэв	Агуулга
Сэдэв 1. Галаас урьдчилан сэргийлэх	Галын тухай ойлголт
	Гэр, сургуульд байдаг гал гаргах эх үүсвэр
	Гал гарах шалтгаан
	Гал гарсан үед авах арга хэмжээ*
Сэдэв 2. Эд зүйлээ хамгаалах, танихгүй хүнтэй харилцах	Хувийн эд зүйлсээ хамгаалах тухай
	Танихгүй хүнтэй хэрхэн харилцах*
Сэдэв 3. Гэртээ мөрдөх дүрэм	Гэрийн ажилд туслахдаа аюулгүй байдлаа хангах
	Гэрийн ажилд туслахдаа аюулгүй байдлаа хангах

	Гэрийн ажилд туслахдаа аюулгүй байдлаа хангах
	Хооллохдоо анхаарах
	Мал, амьтантай зөв харьцах
	Мал, амьтантай зөв харьцах
	Цахилгаан шат (лифт, урсдаг шат) ашиглах
	Тог тасарсан үед хэрхэх вэ?
	Ахуйн химийн бодис – аюултай
	Ахуйн цахилгаан багаж, хэрэгсэлтэй зөв харьцах
	Ахуйн хий –тоглоом биш
	Ахуйн химийн бодис, цахилгаан багаж, хэрэгсэл
	Эмний ач холбогдол, хор холбогдол
Сэдэв 4. Угаарын хий, үзүүлэх тусламж	Хордлого, түүний хор уршиг
	Угаарын хийгээр хордох шинж тэмдэг, үзүүлэх анхны тусламж
Сэдэв 5. Байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн үед авах арга хэмжээ	Байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн тухай
	Байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн үед авах арга хэмжээ
Сэдэв 6. Байгальд мөрдөх аюулгүй байдлын тухай	Ой, тал хээрээр аялах, амрах, зугаалах, зорчихдоо анхаарах зүйл
	Хортой ургамал амьтан гэж юу болох
	Хортой ургамлаар хордох, аюултай амьтанд хазуулах, хатгуулах үед анхны тусламж үзүүлэх